

ГАЗАР ШИМ-ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 07 дугаар сарын 28

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ		Үнэлгээ	Хэрэгжилт
Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна			
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	0	<p>2025 оны 3-р улиралын ээлжит хурлаар</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлага</li> <li>➤ ТУЗ нь шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болно. Энэ нь компанийн жилийн үйл ажиллагааны төсөвт тусгагдсан байна. Гэсэн заалтыг тус тус нэмэлтээр оруулахаар төлөвлөн ажиллаж байна.</li> </ul>
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн №004/009/20240419-004 тоот тогтоолоор Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам</li> <li>➤ 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 002/001/2024/07/04-002 тогтоолуудын хавсралтаар тус тус баталсан.</li> </ul>

3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	0	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2023, 2024 оны үйл ажиллагааны тайланг үнэлж, дүгнэлт гаргуулахаар зохих ажлыг зохион байгуулж ажиллаж байна.</li> </ul>
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ “Газар шим Үйлдвэр” ХК-ийн ТУЗ-хурлаар ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хороодын журам “Нэр дэвшүүлэх хороо” “Аудитын хороо” Марктенги борлуулалтын хороо, “Цалин урамшууллын хороодыг тус тус байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</li> <li>➤ Мөн Залгамж халааны бодлого, Нэр дэвшүүлэх хороо, Дотоод аудитын бодлого, Дотоод хяналтын бодлого, Цалин урамшууллын бодлого, Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам” зэргийг тус тус баталж үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.</li> <li>➤ ТУЗ-ийн 2024.07.04 өдрийн №002/011/20240704 тогтоолын хавсралтаар “Залгамж халааны бодлого”-ыг баталсан. Тус бодлогын 3.1.5 дахь хэсэгт “Хүйсийн зохистой харьцааг зорино. Ингэхдээ ТУЗ-ийн гишүүний бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн эзлэх хувь 30%-аас доошгүй байхыг эрмэлзэнэ” бодлогын баримт бичигт тусгаж өгсөн.</li> </ul>
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	1	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2025 оны жилийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж гишүүдийг чадвахжуулах сургалтыг тухай бүр зохион байгуулж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.</li> </ul>
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой	1	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024 оны 8 дугаар сарын 06-ний №001/011/20240806-001 тогтоолоор П.Нямдоржийг томилсон.</li> </ul>

	явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариушлага хүлээнэ.		
<b>ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариушлагыг хүлээнэ			
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхийг хараат бус гишүүн байхыг зорьж ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулан 2025 оны 4 дүгээр улиралын ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</li> </ul>
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.04.17 өдрийн №004/009/20240419-005 тогтоолоор “Аудитын хорооны ажиллах журам”-ыг баталсан.</li> <li>➤ Тус журмаар Аудитын хорооны бүтэц бүрэлдэхүүн, ажиллах журам, чиг үүргийг нарийвчлан тусган хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</li> </ul>
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2023.11.29-ний өдрийн № 001/005/Н20231129-001 тогтоолын хавсралтаар “Цалин урамшууллын бодлого”-ыг баталсан.</li> <li>➤ ТУЗ-ийн 2024.04.19-ний өдрийн № 003/009/20240419-003 тогтоолын хавсралтаар “Цалин урамшууллын хорооны ажиллах журам”-ыг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>➤ Хорооны даргаар хараат бус гишүүн В.Эрдэнэдалай ажиллаж байна.</li> </ul>

10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.04.19-ний өдрийн № 004/009/20240419-004 тогтоолын хавсралтаар “Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам”-ыг баталсан.</li> <li>➤ ТУЗ-ийн 2024.07.04 өдрийн №002/011/20240704 тогтоолын хавсралтаар “Залгамж халааны бодлого”-ыг тус тус баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Компанийн дүрмийн 7.45 дахь заалтад Маркетинг борлуулалтын хороотой байхаар заасан. Одоо тус хороонд Д.Сэргэлэн (дарга), В.Ганзориг, Д.Гансүх, Ш.Алтанбагана нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.</li> </ul>
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана			
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.01.31-ний өдрийн № 004/007/20240131-004 тогтоолын хавсралтаар баталж, тухай бүрт байгууллагын цахим хуудаст байршуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм журмыг <b>gazarshim.mn</b> вэб сайтаар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллаж байна.</li> </ul>
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	1	<p>Компанийн санхүүгийн тайланг Хөрөнгийн биржийн вэб сайтад байршуулсан.</p> <p>Эдийн засгийн ногоон шилжилт төслийн хүрээнд шалгарч БОНЗ зөвлөгөө өгдөг RCS consulting компанитай 5 сарын 12-ноос 11 сарын 1 хүртэл зөвлөгөө авах байдлаар гэрээ хийсэн.</p>

		6-р сарын байдлаар компанийн хэмжээнд ESG баг байгуулан, БОНЗ зөрүүгийн шинжилгээ хийлгүүлж сайжруулах шаардлагатай 23 ажлыг төлөвлөн ажиллаж байна.
--	--	--

**ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.04.17 өдрийн №004/009/20240419-005 тогтоолын хавсралтаар “Аудитын хорооны ажиллах журам”-ыг баталсан. Тус журмын 3.1.6 хэсэгт хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж өгч журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2023.11.29-ний өдрийн №003/005/Н03/20231129-003 дугаар тогтоолын хавсралтаар “Дотоод хяналтын бодлого”</li> <li>➤ ТУЗ-ийн ТУЗ-ийн 2023.11.29-ний өдрийн №004/005/Н03/20231129-004 дугаар тогтоолын хавсралтаар “Дотоод хяналтын бодлого”-ыг тус тус баталж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах үүднээс 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Дотоод аудитын хөтөлбөр, дотоод аудитын багийн гишүүдийг багтах” гүйцэтгэх захирлын тушаал гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>

**ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	1	
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнан.	2	Эрсдэлийн удирдлагын хороотой байхыг зорьж байна.
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	1	Байршуулсан.
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	0	ТУЗ-ийн 2024.07.04-ний өдрийн 002/011/20240704/ тогтоолоор шинэчлэн хэлэлцэн баталсан.
<b>ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	2	➤ Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын №003 тогтоолоор ТУЗ-ийн 2024 оны төсвийг баталсан.

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/205 тоот тушаалаар М1 албан тушаалын үр дүнгийн үнэлгээний маягтыг шинэчлэн баталсан.</li> <li>➤ Мөн Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д цалин урамшууллын нөхшийг тусгасан.</li> </ul>
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2023.11.29-ний өдрийн 002/005/Н03/20231129-002 тогтоолоор “Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйл,</li> <li>➤ ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээний 2 дугаар зүйлд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тус тус тусгаж өгсөн.</li> </ul>
<p>ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</p> <p>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</p>			
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.01.31-ний өдрийн 005/007/20240131-005 тогтоолоор “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”-ыг баталсан.</li> <li>➤ Тус бодлогоор Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</li> </ul>
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам”-ыг gazarshim.mn сайтад байршуулж, мэдээлэл солилцох, харилцах чиглэлээр үр дүнтэйгээр ажиллаж байна.</li> </ul>
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.8, 2.9, 2.10 дугаар хэсгүүдэд тусгаж өгсөн</li> <li>➤ Дотоод хэрэглэгчдийн санал, гомдол хүлээн авах процессоор тус тус гомдлыг хүлээн авч хуульд заасан хугацаанд гомдлыг барагдуулж ажиллаж байна.</li> </ul>

НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.07.04-ний өдрийн 004/011/20240704-004 тогтоолоор “Ёс зүйн дүрэм”-ийг баталсан.</li> <li>➤ Мөн авилага, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чиглэлээр нэмэлт зохицуулалт оруулж нийт ажилтнуудад сургалт орсноос гадна компанийн вэб хуудсанд байршуулж ажилласан. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.</li> </ul>
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ИТУЗ-ийн 2024.07.04-ний өдрийн 004/011/20240704-004 тогтоолоор “Ёс зүйн дүрэм”-ийг баталсан.</li> <li>➤ Мөн авилага, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чиглэлээр нэмэлт зохицуулалт оруулж нийт ажилтнуудад сургалт орсноос гадна компанийн вэб хуудсанд байршуулж ажилласанаас гадна</li> <li>➤ ТУЗ-ийн 2024.07.04-ний өдрийн 003/011/20240704-003 тогтоолоор “Шүгэл үлээх бодлого”-ыг баталсан.</li> </ul>
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТУЗ-ийн 2024.07.04-ний өдрийн 004/011/20240704-004 тогтоолоор “Ёс зүйн дүрэм”-ийг баталсан. Тус дүрмээр авилага, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чиглэлээр нэмэлт зохицуулалт оруулж өгсөн.</li> </ul>
<b>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>			
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2	<ul style="list-style-type: none"> <li>➤ Gazarshim.mn цахим хуудсаар дамжуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> </ul>

33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	1	ТУЗ -ийн 2025 оны 1 дүгээр сарын хурлаар батлах
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2	➤ Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2	➤ Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	2	➤ ТУЗ-ийн 2023.11.29-ний өдрийн 008/005/Н03/20231129-008 тогтоолоор “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ыг баталж үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.
<b>Нийт авах оноо</b>			<b>72</b>
<b>Авсан оноо</b>			<b>62</b>

ТАНИЛЦСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ХУУЛЬЧ



Ц.ГАНБАТ

Б.ЭНХБИЛЭГ

Л.ХАШ-ЭРДЭНЭ